



АРБИТРЫН МАРГААНЫ ХАРЬЯАЛАЛ

Монголын олон улсын арбитрын
Ерөнхий нарийн бичгийн дарга
М.Шинэбаяр

Улаанбаатар хот
2022



АГУУЛГА

1. Шүүх болон арбитрын хэргийн харьяалал
2. Арбитрын талаарх статистик, тоо баримт

Нэг. Шүүх болон арбитрын хэргийн харьяалал



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ

Арван есдүгээр зүйл.

1. Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.



Нэг. Шүүх болон арбитрын хэргийн харьяалал



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

ИРГЭНИЙ ХУУЛЬ

9 дүгээр зүйл. Иргэний эрх зүйн хамгаалалт

9.1. Иргэний эрх зүйн хамгаалалт нь зөрчигдсөн эрхийг сэргээх зорилготой байна.


9.2. Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч эрхээ хамгаалуулах этгээдийг хуульд заасны дагуу сонгох эрхтэй.

9.3. Иргэний эрх зүйн хамгаалалтыг шүүх, арбитр хуулиар тогтоосон журам, аргаар хэрэгжүүлнэ.



Нэг. Шүүх болон арбитрын хэргийн харьяалал

ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХ



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН АРБИТР



Нэг. Шүүх болон арбитрын хэргийн харьяалал



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 10 дугаар сарын 24-ний өдөр

Улаанбаатар хот

ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ТУХАЙ

6 дугаар зүйл. Үндэсний танхим

2.Үндэсний танхим нь танхимын нийтлэг зорилт, бүрэн эрхийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ дараахь тодорхой бүрэн эрхтэй байна:

4/хуульд зааснаар дэргэдээ гадаад худалдааны арбитр байгуулан ажиллуулах;



Нэг. Шүүх болон арбитрын хэргийн харьяалал

Арбитрын нэр	Байгуулсан огноо	Эрх зүйн эх сурвалж	Харъяалах маргааны төрөл
Байнгын бус/ Эдийн засгийн зөвлөлөөс томилогдсон төлөөлөгч Байнгын бус арбитр	1930.01.17 УБХ-ын Тэргүүлэгчид	“Арбитржаны Дүрэм” баталсан.	Улсын үйлдвэр, байгууллага хоорондын эд хөрөнгийн маргаан
Сайд нарын зөвлөлийн дэргэд Улсын Арбитрын газар	1940.11.12 Сайд нарын зөвлөл 1980.03.15 Сайд нарын зөвлөл Татан буулгаж, УДШ-д нэгтгэсэн	“Улсын Арбитрын Дүрэм”, “Албан ба үйлдвэрийн газруудын хооронд эд хөрөнгийн маргааныг таслан барагдуулах улсын арбитраас хэргийг таслах журам”	Улсын үйлдвэр, байгууллага хоорондын эд хөрөнгийн маргаан + Улсын төлөвлөгөөг биелүүлэх “Аж ахуйн гэрээ”
Худалдааны танхимын дэргэд Гадаад худалдааны арбитрын комисс	1960.07.02 Сайд нарын зөвлөл, МАХН Төв хорооны хамтарсан тогтоол		Гадаад орнуудын худалдааны байгууллага, худалдаачид байгуулсан гэрээ, контракт
МҮХАҮТ-ын дэргэд ▪ 2003 онд Монголын Үндэсний Арбитр ▪ 2013 онд Монголын Олон Улсын ба Үндэсний Арбитр ▪ 2017 онд Монголын Олон Улсын Арбитр	МҮХАҮТ-ын УЗ-ийн тогтоолууд	<ul style="list-style-type: none"> ▪ 1995 оны Гадаад худалдааны арбитрын тухай хууль ▪ -2003 онд Арбитрын тухай хууль баталсан ▪ 2017 онд Арбитрын тухай хууль /шинэчилсэн найруулга/ 	Эдийн ба эдийн бус баялгаас үүдэлтэй иргэн, хуулийн этгээд хоорондын маргаан

Нэг. Шүүх болон арбитрын хэргийн харьяалал

МОУА-ын бүтэц, зохион байгуулалт



Нэг. Шүүх болон арбитрын хэргийн харьяалал

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Иргэний хэрэг үүсгэх үндэслэл, хэргийн харьяалал

12 дугаар зүйл. Иргэний хэрэг үүсгэх үндэслэл

12.1. Шүүх дараахь үндэслэлээр иргэний хэрэг /цаашид "хэрэг" гэх/ үүсгэж болно:

12.1.1. эдийн ба эдийн бус баялагтай холбоотой эрх нь зөрчигдсөн тухай эрх зүйн харилцаанд оролцогч этгээдээс гаргасан нэхэмжлэл;

Арбитр

12.1.2. бусдын эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалж шүүхэд мэдүүлэх эрх нь хуулиар олгогдсон этгээдээс гаргасан нэхэмжлэл;

12.1.3. онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлүүлэхээр хуульд заасан асуудлаар сонирхогч этгээдээс гаргасан хүсэлт;

12.1.4. Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд зааснаас бусад байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа болон тэдгээрийн гаргасан захиргааны актын талаар гаргасан гомдол;

Шүүх

12.1.5. хуульд заасан бусад үндэслэл.



Нэг. Шүүх болон арбитрын хэргийн харьяалал

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Иргэний хэрэг үүсгэх үндэслэл, хэргийн харьяалал

13 дугаар зүйл. Хэргийн харьяалал

13.1.Энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан үндэслэлээр гаргасан нэхэмжлэл, хүсэлт, гомдол /цаашид “нэхэмжлэл” гэх/-ыг шүүх харьяалан шийдвэрлэнэ.

13.2.Хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан буюу **зохигч хэлэлцэн тохиролцсон** бол иргэн, хуулийн этгээдийн хооронд үүссэн маргааныг арбитр шийдвэрлэнэ.


13.3.Талууд байгуулсан гэрээндээ маргаан гарвал арбитраар шийдвэрлүүлэхээр заагаагүй буюу энэ талаар хэлэлцэн тохиролцоогүй, эсхүл Засгийн газар хоорондын хэлэлцээрээр маргааныг арбитраар шийдвэрлүүлэхээр заагаагүй бол нэхэмжлэлийг шүүх шийдвэрлэнэ.

13.5.Талууд байгуулсан гэрээндээ маргаан гарвал эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар шийдвэрлүүлэхээр тохиролцсоныг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх журам тогтоосон гэж үзнэ.

Арбитр

Шүүх

Эвлэрүүлэн
зуучлал



Нэг. Шүүх болон арбитрын хэргийн харьяалал

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Иргэний хэрэг үүсгэх үндэслэл, хэргийн харьяалал

16 дугаар зүйл. Шүүхийн онцгой харьяалал

16.1. Үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой буюу эд хөрөнгийн битүүмжлэлийг нээлгэх тухай нэхэмжлэлийг тухайн эд хөрөнгө байгаа газрын шүүхэд гаргана.

16.2. Гадаад улсын нутаг дэвсгэр дээр байгаа Монгол Улсын иргэн, хуулийн этгээдтэй холбоотой нэхэмжлэлийг нэхэмжлэгчийн оршин суугаа /оршин байгаа/ газрын, эсхүл хариуцагчийн эд хөрөнгө байгаа газрын шүүхэд гаргаж болно.

16.3. Өв залгамжлагч өвийг хүлээн авахаас өмнө өвлүүлэгчийн үүрэг гүйцэтгүүлэгчээс гаргах нэхэмжлэлийг өвлөгдөх эд хөрөнгө бүхэлдээ буюу түүний гол хэсэг нь байгаа газрын шүүхэд гаргана.

16.4. Тэжээн тэтгэхтэй холбогдсон нэхэмжлэлийг нэхэмжлэгчийн оршин суугаа газрын шүүхэд гаргана.

Арбитр
харьяалана

Шүүхийн
харьяалал
доторхи
хуваарилалт

Түгээмэл буруу ойлголт!





**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН
ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ**

2021 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 102/ШЗ2021/13052

Улаанбаатар хот

Хэргийг хэрэгсэхгүй болгох тухай

Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ш.Оюунтуул даргалж, тус шүүхийн танхимд нээлттэй хийсэн шүүх хуралдаанаар

нэхэмжлэгч:

нэхэмжлэлтэй,

хариуцагч:

тоотод оршин суух,

хариуцагч:

тоотод оршин суух,

хариуцагч:

хариуцагч:

үл хөдлөх хөрөнгийн өмчлөгчөөр тогтоолгох, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг өөрийн нэр дээр гаргуулах тухай үндсэн нэхэмжлэлтэй, үл хөдлөх эд хөрөнгийг хууль бус эзэмшлээс чөлөөлүүлэх, Х-LD016 дугаар Орон сууц бариулах гэрээнээс татгалзаж, 115 000 000 төгрөг гаргуулах тухай сөрөг нэхэмжлэлтэй иргэний хэргийг хянан хэлэлцэв.

Нэхэмжлэгч ... 2008 оны 06 сарын 09-ны өдөр №Х-LD016 Орон сууц захиалан бариулах гэрээний дагуу хөрөнгийн үнийг төлж барагдуулсан тул үл хөдлөх хөрөнгийн өмчлөгчөөр тогтоолгох, өөрийн нэр дээр үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ гаргуулах тухай... нэхэмжлэлийн шаардлага гаргасныг,

хариуцагч нар эс зөвшөөрч ...орон сууц бариулах гэрээнээс татгалзаж, хохирол 115 000 000 төгрөг гаргуулах, тухайн маргаан бүхий үл хөдлөх хөрөнгийг нэхэмжлэгчийн хууль бус эзэмшлээс чөлөөлөх тухай... сөрөг нэхэмжлэлийн шаардлага гарган маргажээ.

2008 оны 06 сарын 09-ны өдөр №Х-LD016 Орон сууц захиалан бариулах гэрээний 5.1-д ямар нэг асуудлаар маргаан гарвал эвийн журмаар шийдвэрлэх бөгөөд үл тохиролцох тохиолдолд арбитрайн шүүхээр шийдвэрлүүлнэ. Шүүхийн шийдвэр эцсийн болохыг хоёр тал зөвшөөрнө гэж тохиролцсон байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т ...зохигч хэлэлцэн тохиролцсон бол иргэн, хуулийн этгээдийн хооронд үүссэн маргааныг арбитр шийдвэрлэнэ, мөн хуулийн 13.3-т ...талууд байгуулсан гэрээндээ маргаан гарвал арбитраар шийдвэрлүүлэхээр заагаагүй буюу энэ талаар хэлэлцэн тохиролцоогүй ... бол нэхэмжлэлийг шүүх шийдвэрлэнэ гэжээ.

2008 оны 06 сарын 09-ны өдөр №Х-LD016 Орон сууц захиалан бариулах гэрээнээс үзэхэд талууд маргаан гарвал арбитраар шийдвэрлүүлэхээр хэлэлцэн тохиролцсон байх бөгөөд хэргийн харъяалал зөрчсөн, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах хуульд заасан үндэслэл хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх үед тогтоогдсон тул талуудын гаргасан үндсэн болон сөрөг нэхэмжлэлтэй иргэний хэргийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1, 65.1.10, 117 дугаар зүйлийн 117.1-д зааснаар хэрэгсэхгүй болгох үндэслэлтэй гэж шүүхээс дүгнэв.

Нэг. Шүүх болон арбитрын хэргийн харьяалал

АРБИТРЫН ТУХАЙ ХУУЛЬ

9 дүгээр зүйл. Арбитрын харьяаллын маргаан

9.1.Шүүхэд тусгайлан харьяалуулснаас бусад, арбитрын хэлэлцээрт тусгасан аливаа маргааныг арбитрын журмаар шийдвэрлэнэ.

Жишээ нь:



АВТО ЗАМЫН ТУХАЙ ХУУЛЬ

32 дугаар зүйл. Маргаан шийдвэрлэх

32.1.Авто зам, замын байгууламжийг барих, эзэмших, ашиглахтай холбогдон үүссэн маргааныг холбогдох эрх бүхий байгууллага шийдвэрлэнэ.

32.2.Энэ хуулийн 32.1-д заасан эрх бүхий байгууллага маргааныг шийдвэрлэж чадаагүй тохиолдолд шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ

АРБИТРЫН ТУХАЙ ХУУЛЬ

8 дугаар зүйл. Арбитрын хэлэлцээр, түүний хэлбэр

8.11.Хэрэглэгчийн эрхтэй холбоотой маргааны тухайд арбитрын хэлэлцээрийг гагцхүү маргаан үүссэний дараа талууд бичгээр тусад нь байгуулах бөгөөд арбитрын ажиллагааны харьяаллыг заасан байна.



ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1.1. “Хэрэглэгч” гэж бараа, ажил, үйлчилгээг үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны бус, зөвхөн хувийн болон гэр бүл, ахуйн хэрэгцээгээ хангахад зориулан захиалж, худалдан авч, үйлчлүүлж байгаа, эсхүл хэрэглэж байгаа хувь хүнийг

Нэг. Шүүх болон арбитрын хэргийн харьяалал

Бүрэн бус, тодорхойгүй арбитрын хэлэлцээр нь зөрчигдсөн эрхийг сэргээх боломжгүйд хүргэнэ !

Арбитрын хэлэлцээр

АРБИТРЫН ХЭРЭГ

Арбитрын хэлэлцээрийг маргаан гарсны дараа байгуулна !

Нийтлэг агуулгаар шүүхэд харьяалагдах маргаан:

- Захиргааны маргаан
- Өрсөлдөөний маргаан
- Хөдөлмөрийн маргаан
- Эдийн ба эдийн бус баялгаас бусад

Шүүхэд тусгайлсан харьяалалгүй

Хэрэглэгчийн эрх

Хоёр. Арбитрын талаарх статистик, тоо баримт

ХУВИЙН ЭРХ ЗҮЙН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Х.НЯМБААТАР

БАГА ҮНИЙН ДҮНТЭЙ ИРГЭНИЙ ХЭРЭГ /10 САЯ ТӨГ ХҮРТЭЛХ/

Зээлийн гэрээний маргаан шийдвэрлэх дундаж хугацаа **6,2** жил
Хамгийн ихдээ -16,6 жил зарцуулсан

2017-2019 онд

Анхан шатны шүүх **33%**

Давж заалдах шатны шүүх **24,7%**

Хяналтын шатны шүүх **23,8%**

Иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэл 2021 оны 8-р сарын байдлаар **1,6 тэрбум** төгрөгийн гүйцэтгэх хуудаснаас **1,5 тэрбум** төгрөгийн гүйцэтгэх хуудас биелэгдээгүй

Дэлхийн банкны "Шүүхийн үйл ажиллагааны чанарын индекс" 2020 онд Монгол Улс **5.5/18**

2020 онд Монгол Улс

15,6 сая төгрөгийн иргэний нэхэмжлэлийг шийдвэрлэхэд

374 хоног, 22,9% зардал


ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ

Муу дүн авсан үзүүлэлтүүд:

- 31** Арилжааны хэргийн тусгайлсан шүүх/танхим байгаа эсэх;
- Бага үнийн дүнтэй хэргийн шүүх/шуурхай шийдвэрлэх процесс байгаа эсэх;
- Гомдол хүсэлтийг цахимаар гаргах, Улсын тэмдэгтийн хураамжийг цахимаар төлөх, шүүхийн үйл ажиллагааг цахимжуулсан эсэх;
- Урьдчилсан хэлэлцүүлэг хийх; Маргааныг шүүхийн бус аргаар шийдвэрлэхийг урамшуулах

Хоёр. Арбитрын талаарх статистик, тоо баримт


Хэрэг шийдвэрлэж буй дундаж хугацаа /сараар/



* 2021 оны байдлаар


Хоёр. Арбитрын талаарх статистик, тоо баримт

Хүлээн авсан хэргийн тоо /жилээр/




Хоёр. Арбитрын талаарх статистик, тоо баримт

Хэргийн оролцогч /улсаар/



Хоёр. Арбитрын талаарх статистик, тоо баримт

ШИЙДВЭРЛЭГДСЭН ХЭРЭГ МАРГААН /ГЭРЭЭНИЙ ТӨРЛӨӨР/



* 2020 оны байдлаар

Хоёр. Арбитрын талаарх статистик, тоо баримт

ХҮЛЭЭН АВСАН ХЭРГИЙН ТОО



ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРГИЙН ТОО



Хоёр. Арбитрын талаарх статистик, тоо баримт

2021 онд нийт хүлээж
авсан хэргийн тоо **187**

2021 онд ажиллагаа
явуулсан хэрэг **247**

2021 онд олгосон
тодорхойлолтын тоо **289**

2021 ОНД ХҮЛЭЭЖ АВСАН ХЭРГИЙН
НЭХЭМЖЛЭЛИЙН НИЙТ ҮНИЙН ДҮН
39 ТЭРБУМ ТӨГРӨГ

2021 ОНД ХЭРЭГ ШИЙДВЭРЛЭСЭН
ДУНДАЖ ХУГАЦАА **93** ХОНОГ ~ **3** сар

Хоёр. Арбитрын талаарх статистик, тоо баримт

МҮХАҮТ-ын дэргэдэх
Монголын Олон Улсын Арбитрын
арбитрчид

100




Монголын арбитрч

68

Олон Улсын арбитрч

32



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА



МОНГОЛЫН
ОЛОН УЛСЫН АРБИТР



70111545



11-324620



info@arbitr.mn



www.arbitr.mn